



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №01

2019 оны 1-р сарын 01-04

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ


Улсын хэмжээнд 2019 оны 1 дүгээр сарын 04-ний өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын галзуу өвчний эрсдэлд өртсөн 1 яаралтай дуудлагыг хүлээн авч хариу арга хэмжээг авч ажилласан байна.

1.1. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:

Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумаас галзуу өвчний эрсдэлд өртсөн 1 тохиолдол мэдээлэгдсэн. Өвчтөн “Ц” 31 настай, эрэгтэй, малчин. 12 дугаар сарын 26-27-нд шилжих шөнө галзуугийн сэжигтэй чононд уруулсан.

Өвчтөнийн биеийн байдал дунд, орчиндоо харьцаатай, баруун гарын шуу орчимд урагдсан шархтай. 1 дүгээр сарын 02-нд Хайрхандулаан сумын Эрүүл мэндийн төвд шархны анхны цэгцлэлт хийлгэж, галзуугийн эсрэг вакцины I-р тунг хийлгэсэн. ЗӨСҮТ-өөс 1 дүгээр сарын 02-нд ийлдэс эмчилгээ хүргүүлж, эмчилгээг тухайн өдөртөө эхэлсэн байна. Чоныг устгаж, дээж авч аймгийн МЭАЦЛ-т шинжлүүлэхэд 12 дугаар сарын 31-ний шинжилгээний хариугаар галзуу өвчин болох нь тогтоогдсон байна.

Он гарсаар галзуу өвчний эрсдэлд өртсөн 1 тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 80%-иар, эпидемиологийн 1 дэх долоо хоногтой харьцуулахад 4 сэжигтэй тохиолдлоор тус тус бага үзүүлэлттэй байна.



Өвөрхангай аймгийн ЗӨСТ аймгийн галзуу өвчнөөс сэргийлэх, сэрэмжлүүлэг сурталчилгааг эрчимжүүлэн ажиллана уу?

ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

Монгол улсад:

Мал, амьтны галзуу өвчин: Дундговь

Дундговь аймгийн Дэрэн сумын Саруул багийн “Дугуй булаг” гэдэг газар 12 дугаар сарын 28-ний өдөр малчин “Б”-ийн 1 үхэрт мал, амьтны галзуу өвчний шинж тэмдэг илэрсэн тул, дээж авч аймгийн МЭАЦЛ-д шинжлүүлэхэд галзуу өвчин болох нь батлагдсан байна. 12 дугаар сарын 28-ны өдрөөс тус сумын Засаг даргын захирамжаар хязгаарлалтын дэглэм тогтоосон. Нийт 500 м² талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийгээд байна.

Эх сурвалж: ОБЕГ

Мал, амьтны галзуу өвчин: Өвөрхангай

Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумын Бурхант багийн “Мухал” гэдэг газар 12-р сарын 27-ны өдөр малчин “Б”-ийн малд мал, амьтны галзуу өвчний шинж тэмдэг илэрсэн тул, дээж авч аймгийн МЭАЦЛ-д шинжлүүлэхэд галзуу өвчин болох нь батлагдсан. Тус суманд 1-р сарын 02-ны өдрөөс тус сумын Засаг даргын захирамжаар хязгаарлалтын дэглэм тогтоож, нийт 800 м² талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн.

Эх сурвалж: ОБЕГ

Олон улсад:


Мал, амьтны галзуу өвчин: Малайз

Малайз улсын Мал эмнэлгийн газраас мэдээлснээр 10-р сарын 29-нөөс, 12-р сарын 14-ны өдрүүдэд Сарабак хотын Кучинг, Мири тус мужуудад мал, амьтны галзуу өвчин бүртгэгдэж, 2751 нохой, 3 муур өртөмхий байснаас, 2 нохой, 1 муур өвчилж үхэн, 111 нохой, 1 муурыг устгажээ. Тус хотын Кедахт 277 нохой, Перлист 1864 нохой, Сарабакад 100515 нохой, 8541 мууранд, нийт 111197 гэрийн тэжээвэр амьтанд вакцинжуулалт хийгджээ.




Малын хэл хөхрөх өвчин: Грек

Грек улсын Хөдөө аж ахуй яамнаас мэдээлснээр тус улсын нэг бүс нутагт малын хэл хөхрөх өвчин бүртгэгдсэн. Үхрийн фермд 30 үхэр өртөмхий байснаас, 1 үхэр уг өвчнөөр өвчилсөн тухай мэдээлжээ.



Шувууны томуу өвчин: Энэтхэг


Энэтхэг улсын Орисса хотын Пури мужид шувууны томуугийн H5N1 вируст халдварын дэгдэлт бүртгэгдэж, 548 шувуу өртөмхий байснаас, 548 шувууг устгасан. Тус голомтод тандалт судалгаа хийж, хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.




Эх сурвалж: ДАЭМБ

Эбола вирус халдвар: БНАКУ

Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад 12 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар Хойд Киву, Итури мужийн 16 Эрүүл мэндийн төвөөс мэдээлэгдсэн.



Эбола вирус халдварын сэжигтэй 591(543 батлагдсан, 48 болзошгүй) тохиолдол, үүнээс 357 нас баралт бүртгэгдсэн. Нас баралтын түвшин 60%-тай байна.



Эх сурвалж: ДЭМБ